

**“УЛААНБААТАР ХИВС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
2026-04-09-НИЙ ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2026-04-09

Улаанбаатар хот

“Улаанбаатар хивс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хурал 2025-04-09-ний 13:00 цагт компанийн хурлын танхимд эхлэв.

Н.Батцэцэг: Тооллогын комисс ирц тоолсон дүнг нэгтгэх хооронд хурлын дарга Ё.Энхтөр хурлын дэгийг танилцуулна.

Хурлын дарга Ё.Энхтөр: Компанийн ТУЗ-ийн 2026-02-12-ны өдрийн хурлын тогтоолоор ХЭХ-ын даргаар Ё.Энхтөр миний биеийг, тооллогын комиссоор ер. ня-бо Б.Доржсамбуу, маркетингийн менежер С.Баясах, ня-бо Б.Соёлмаа нарыг томилон баталсан. Иймд хурлыг даргалж байна. Хурлын дэгийг танилцуулъя.

- Ирцийг мэдээлэх: С.Баясах танилцуулна: /10 минут/
- Компанийн үйл ажиллагааны 2025 оны гүйцэтгэл, 2026 оны зорилтын тухай: Ц.Зоригт танилцуулна /20 минут/
- Компанийн 2024 оны санхүүгийн тайланд Аудитын байгууллагаас өгсөн дүгнэлт: Б.Баясгалан танилцуулна./10 минут/
- Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны зардлын төсөв батлах асуудлыг Н.Батцэцэг танилцуулна. /10 минут/
- Хэлэлцсэн асуудлын талаар санал, шүүмжлэл, асуулт тавих /хүн бүр 5 минут/
- Компанийн ТУЗ-ийн сонгууль явуулах
- Хэлэлцсэн асуудлаар санал хураах, дүнг танилцуулах Тооллогын комисс / 30 минут/
- Хурлыг 13:00-17:00 цаг хүртэл хуралдуулахаар төлөвлөв.

Ш.Энхбаяр: Тооллогын комисст хүн нэмж оруулах саналтай.

Ё.Энхтөр: 2026-02-12-ны ТУЗ-ийн хурлын тогтоолд, ХЭХ-ын үеэр тооллогын комисст хүн нэмж оруулахыг нээлттэй үлдээх заалт орсон тул зөвшөөрье.

Ш.Энхбаяр: ТУЗ-ийн гишүүн У.Мөнхзулыг оруулъя.

Зөвшөөрч У.Мөнхзулыг тооллогын комиссын бүрэлдэхүүнд оруулав.

Тооллогын комиссын гишүүн С.Баясах: Компанийн нийт хувьцааны 95,8% буюу 387715 ширхэг хувьцааг төлөөлсөн 19 хувьцаа эзэмшигчид оролцож буй тул хурал хүчин төгөлдөр болох тухай тогтоол № 1-ийг уншиж танилцуулав.

Ё.Энхтөр: Дэгийн дагуу 1-р асуудлыг ТУЗ-ийн дарга Ц.Зоригт танилцуулна.

Ц.Зоригт: Та бүхэнд тараагдсан материалд 2025 оны тайлан байгаа тул товч танилцуулъя. Тус компани үнэт цаасны 53 компанид харьяалалтай 886 хувьцаа эзэмшигчтэй байна. Компанийн зах зээлийн үнэлгээ: 2020-04-01-ний байдлаар, 17,68 тэрбум төгрөг. Жилийн дундаж үнээр нэгж хувьцааны үнэ: 30000₮-44960₮ - ний хооронд хэлбэлзэж байна. Нийт хувьцааны 95,7% нь 7 хувьцаа эзэмшигчид төвлөрсөн байна. Компани жил бүр ноогдол ашиг тарааж ирсэн ба сүүлийн 5 жилд гэхэд компани үйл ажиллагааны үр дүнгээр ойролцоогоор 3,0 тэрбум ₮-ийн ноогдол ашиг хуваарилаад байна. Одоо компанийн 2025 оны үр дүнгээр нэгж хувьцаанд мөн 2000 төгрөгний ноогдол ашиг хуваарилахаар шийдвэр гарсан.

СЗХ-ны тогтоолын дагуу “Компанийн засаглалын кодекс”-ын хэрэгжилт, 2025 оны эхний хагас жилд 65,3%-тай дүгнэгдсэн. Нийт 113 компанийг 48 байр эзлүүлэхэд 21-р байранд орсон байна.

Борлуулалтын талаар: 2024 онд 50668,4 м2 буюу 7,583 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх онтой харьцуулахад 13,7%-аар өссөн. 1078,8 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллав. Компанийн фейсбүүк дагагчдын тоо өнгөрсөн оныхоос 32% өссөн. Нэр төрлүүдээс Алтанбулаг брэнд нийт борлуулсан хивсний 69,29 % буюу хамгийн өндөр борлуулалттай байна. Өрсөлдөгчийн хувьд, “Эрдэнэт хивс” ХХК болон БНХАУ-ын хямд хивс худалдаачид байсан бол БНТУ-аас хямд болон маш бага хэсэг нь үнэтэй хивс импортлогдон ирж, зах зээлд борлогдож, өрсөлдөөн их өсч байна. БНТУ-аас өмнөх жилээс 30 % илүү хэмжээний хивс орж иржээ.

Үйлдвэрлэлийн талаар: 52068 м2 хивс үйлдвэрлэсэн.

327,9 тн ноос худалдан авсан.

Нарийн ээрэх цехэд 117,3 тн ноос боловсруулж 80,6 тн ээрмэл ээрлээ. Төлөвлөгөөний биелэлт 97,6% байв. ТТАК 90,29%. Нийт сул зогсолтын 63% нь дамжлагын нөөц алдагдсанаас, 14 % нь ажиллах хүчний дутагдлаас шалтгаалжээ.

24/2, 12/1 ба 14,5/1 номерын утас 2125 кг-ийг ээрсэн.

Будах цехэд 89400 кг ээрмэл будлаа.

Хялгас ялгах цехэд ялгасан ноосны гарц урьд жилийнхээс 10 орчим % -аар илүү байв.

Нэхэх цех 48664,62 м2 хивс нэхсэн нь төлөвлөгөөг 91,7 % -ийн биелүүлсэн байв. Энэ нь шинэ машины Европоос тээвэрлэлт саатсантай холбоотой байв.

Буйдангийн ком бүтээлэг 150 ш, эсгий гудас 32 ширхэг, хивсэн углааш 200 хос, машины иж бүрдэл хивс 97 ширхгийг тус тус үйлдвэрлэв.

Инженерийн байгууламжийн хэсэг компанийн барилгын чердак, түнелийг цэвэрлэж, шаардлагатай холболт, засвар үйлчилгээг хийж компанийн найдвартай ажиллах нөхцлийг бүрдүүлж ажиллалаа. Шинээр суурилуулсан машин болон буулгаж байгаа машинуудын цахилгааны ажлуудыг хариуцан ажиллав. 79,4 сая төгрөгийн эрчим хүчний бодит хэмнэлт гаргав.

Хүний нөөц:

- Ажиллагсдын тогтвор суурьшил 94,1%, дундаж нас 42,2 байна.
- Компанийн хэмжээнд, 2025 онд ажлын цагийн фондыг 93% ашиглаж ажиллалаа.
- 115 ажиллагсадтай байснаас 27 ажилтан шинээр орж, 24 ажилтан хөдөлмөрийн гэрээ цуцаллаа.

Техник, технологийн шинэчлэлт:

- МУЗГ-ын “Цагаан алт” хөтөлбөрийн хүрээнд зээл авч, ХБНГУ-ын “ШҮЙНХЕРР” Компанийн “АЛЬФА360 нэхэх машиныг худалдан авч суурилууллаа.
- Будах цехэд 10, 25, 50 кг-аар задгайгаар будах машинууд суурилуулсан.

2025 оны төлөвлөгөө:

- Үйлдвэрлэл: 55 000 М2
- Борлуулалт : 8 500 000 мян.₮
- Хөрөнгө оруулалт: 300 000 мян. ₮
- Цэвэр ашиг: 1 210 000 мян. ₮
- Үйлдвэрлэлийн нэгж өртөг: 110 000 ₮/м2

2026 онд компани мэргэжилтэй ажилчдыг нөөцийг бэлтгэх, бололцогоо дайчлах замаар шинээр суурилуулсан нэхэх машины бүтээмжийг бүрэн ашиглаж, үйлдвэрлэлээ нэмэгдүүлж, өртгөө бууруулан, хувьцааны өгөөжийг нэмэгдүүлэх зорилттой байна.

Ч.Энхтөр: Хэлэлцэх 2-р асуудал: Санхүүгийн 2025 оны байдалд аудитын байгууллагаас өгсөн дүгнэлтийг ТУЗ-ийн аудитын хорооны дарга Б.Баясгалан танилцуулна.

Б.Баясгалан: Сүүлийн 3 жил “Аятакс Аудит” ХХК-аар аудит хийлгэдэг байсан Энэ жил ч энэ компанийг сонгон гэрээгээ хийж, материалаа өгөөд байтал уг компанийн захирал нь 24/III-нд хувийн шалтгаанаар гэрээгээ биелүүлж чадахгүйд хүрсэн хариу өгсөн тул бид богино хугацаанд өөр компани буюу “Их Наяд Аудит” ХХК-г олж гэрээ хийсэн. ТУЗ-ийн эрсдэл-аудитын хорооны гишүүдэд мэдэгдсэн.

Тараах материал дээр байгаа дүгнэлтийг бүтэн уншиж танилцуулав.

Ё.Энхтөр: 3-р асуудал буюу ТУЗ-ийн 2026 оны үйл ажиллагааны зардал ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Н.Батцэцэг танилцуулна.

Н.Батцэцэг: ТУЗ-ийн 2026 оны зардлын төсвийг ТУЗ-ийн 2-р сарын 12-ны хурлаар баталсан байгаа. Одоо хувьцаа эзэмшигчдийн хуралд батлуулахаар оруулж байна. Гишүүдийн цалин, хуралд оролцсон урамшуулал, бичиг хэргийн зардал, холбооны зардал, сургалт, аттестатчилалын зардал гээд нийт 120,0 сая ₮-ийг төлөвлөсөн байна. Ноднингийнхоос нэмэгдсэн шалтгаан нь, Хөдөлмөр Нийгмийн Түншлэлийн 3 талт үндэсний хорооны тогтоолоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ өссөнтэй холбоотойгоор гишүүдийн цалинг өсгөсөн явдал байна.

Ё.Энхтөр: Хэлэлцэх асуудал дууссан тул асуулт хариулт, санал, шүүмжлэлдээ орёе. Тооллогын комисс саналаа цуглуулж, тооллогоо хийх ёстой.

Ш.Уламбаяр: Би компанийн ердийн гишүүнд нэрээ дэвшүүлмээр байна.

Л.Цэвээнравдан: Миний саналаар: Энэ нь хуулийн хувьд боломжгүй.

Ё.Энхтөр: МУ-ын Компанийн тухай хуулийн 63.10. дугаар зүйлд ХЭХ төлөвлөснөөс өөр асуудал хэлэлцэхгүй гэсэн заалт байгаа тул шинээр нэр дэвшүүлж болохгүй.

Ш.Энхбаяр: Би 2026-02-12-ны ТУЗ-ийн хурал дээр: ХЭХ дээр заалнаас ТУЗ-д нэр дэвшүүлж болох уу гэж асуусан. Болно гэж хариулсан.

Н.Батцэцэг: Нэрээ дэвшүүлэх байсан бол хурлаас 14 хоногийн өмнө материалаа ирүүлж, ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороогоор хэлэлцүүлэх ёстой байсан биш үү?

Ё.Энхтөр: Тэгвэл 2 замаар хуралд оролцогчдоос санал авъя. Эсвэл, оролцогчдоос гар өргүүлж санал авах, нөгөөтэйгүүр оролцогчдын хувьцааны тоогоор санал авах гэсэн 2 арга байна.

Ц.Зоригт: Оролцогчдоос гарыг нь өргүүлж, санал авах нь зохисгүй. 886 хувьцаа эзэмшигчдийг энэ 19 хувьцаа эзэмшигч төлөөлөхгүй. Уламбаярыг нэмж нэр дэвшигчээр оруулахад болохгүй гэсэн асуудал алга.

Ё.Энхтөр: Ш.Уламбаярыг саналын хуудсанд нэрийг нэмж дахиж хэвлээд санал хураалтаа явуулъя.

ТУЗ-ийн нбдарга саналын хуудсыг засч, дахин хэвлэн тарааж, оролцогчид саналаа дахин өгөв.

Ё.Энхтөр: Асуулт, санал, шүүмжлэлээ үргэлжлүүлье.

С.Мягмарсүрэн: Одоо компани үйл ажиллагааны ашгийн 60% нь үйлдвэрлэлийн бус орлогоос олж байна. Үйлдвэрлэлээс олох ашгаа нэмэгдүүлэхэд гол асуудал юу вэ?

Ц.Зоригт: Үйлдвэрлэлээ өсгөж нэмэгдүүлэх ёстой. Үүний тулд бид хүчин чадал өндөртэй машин авч суурилуулсан байгаа. Цаашид бүтээмжээ өсгөх талаар анхаарч ажиллана.

Ч.Даваадолгор: Түүхий эдийн хангалт ямар вэ?

Ё.Энхтөр: Үндсэн түүхий эд бол ноос. Манай компани баруун аймгаас голчлон ноосоо авдаг. Чанарын хувьд сайн учраас. Баянхонгорт голчлон бэлтгэдэг. Ер нь бол ноосны хангамж сайн.

Хурал түр завсарлав.

С.Баясах : Тооллогын комиссын тогтоол №2-ыг танилцуулъя. Хэлэлцсэн эхний 3 асуудалд хуралд оролцогчид 100 % “Зөвшөөрсөн” санал өгсөн байна.

Тооллогын комиссын дарга Б.Доржсамбуу: ТУЗ-ийн гишүүдийн сонгуулиар ТУЗ-д сонгогдсон энгийн ба хараат бус нэр дэвшигчдийн авсан саналын тоо бүхий тооллогы комиссын тогтоолыг танилцуулав.

Ё.Энхтөр: Ингээд хурал асуудлаа хэлэлцэж дууссан тул хэлэлцсэн асуудлуудаар ХЭХ-ын тогтоол гарна. Эдгээрийн төслийг танилцуулъя. /Тогтоолын төслүүдийг уншиж сонсгов./

№1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны үр дүн, 2026 оны үндсэн зорилтын тухай

№2. Аудитын байгууллагын дүгнэлтийн тухай

№3. Компанийн ТУЗ-ийн ердийн гишүүдийг сонгох тухай

№4. Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүдийг сонгох тухай

№5. Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны 2026 оны зардлыг батлах тухай

Ийм тогтоолууд гарсан байна. Тогтоолуудаа батлах уу?

Оролцогчид 100% гараа өргөж батлав.

Ё.Энхтөр: Хуралд хүрэлцэн ирж оролцсон та бүхэнд баярлалаа. Сайн сайхныг хүсье.

Хурал үүгээр 16:20 –д өндөрлөв.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:  ТУЗ-ийн нбд: Н.Батцэцэг

Танилцсан: Хурлын дарга  Ё.Энхтөр

